

UCS 1109B:2025

НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ




Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын
барилгын дотор засалд тавигдах шаардлага

НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын
барилгын дотор засалд тавигдах шаардлага

*Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 25/07-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	4
2. Норматив эшлэл	4
3. Нэр томъёоны тодорхойлолт	4
4. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага	5
5. Материалд тавигдах ерөнхий шаардлага	6
6. Хана	6
7. Шал	7
8. Шат, хашлага	8
9. Цонх	9
10. Хаалга	10
11. Гэрэлтүүлэг, цахилгааны тоноглол	11
12. Халаалт, агааржуулалт	12
13. Ариун цэврийн өрөө	13
14. Аюулгүй байдалд тавигдах шаардлага	15
15. Шалгах хуудас	17
Ашигласан материалын жагсаалт	18

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ариун цэврийн өрөөний шалны хэсэглэл	8
Зураг 2. Шатны стандарт	8
Зураг 3. Брайл тэмдэглэгээг шатны бариул дээр суурилуулах	9
Зураг 4. Дотор хаалганы хэмжээс	10
Зураг 5. Хамгаалалттай цахилгааны залгуур	12
Зураг 6. Бүлгийн өрөө	12
Зураг 7. Ариун цэврийн өрөө	13
Зураг 8. Ариун цэврийн өрөөний таних тэмдэг	15

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хүүхдийн эргономик хэмжээ (жишээ)	5
Хүснэгт 2. Үндсэн өрөө тасалгааны 1 хүүхдэд ногдох талбайн хэмжээ, м ² -аар	5
Хүснэгт 3. Анхааруулах хавтангийн хэмжээ (жишээ)	9
Хүснэгт 4. Өрөө тасалгаанд байвал зохих гэрэлтүүлгийн хэмжээ	11
Хүснэгт 5. Суултуурт тавигдах шаардлага	14
Хүснэгт 6. Угаагуурт тавигдах шаардлага	14
Хүснэгт 7. Шалгуур үзүүлэлт	17



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 45/07

Улаанбаатар хот

Нийгмийн дэд бүтцэд хамаарах
хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн “Нийгмийн дэд бүтэц” бүлэгт хамаарах дор дурдсан хотын стандартуудыг хавсралтаар баталсугай.

1.1. UCS1106B:2025 “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын гадна засалд тавигдах шаардлага” хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS1107B:2025 “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын дотор засалд тавигдах шаардлага” хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

1.3. UCS1108B:2025 “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын гадна засалд тавигдах шаардлага” хотын стандартыг гуравдугаар хавсралтаар;

1.4. UCS1109B:2025 “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын дотор засалд тавигдах шаардлага” хотын стандартыг дөрөвдүгээр хавсралтаар;

1.5. UCS1101C:2025 “Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл” хотын стандартыг тавдугаар хавсралтаар;

2. Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүсчилсэн хөгжлийн хороо (Л.Ариунтуяа)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

17.10.2025

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/07
дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ

UCS1109B:2025

“ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫН ДОТОР ЗАСАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын дотор засал, интерьер дизайныг төлөвлөх, гүйцэтгэх, хүлээн авахад дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- БНБД 31-24-22 – Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт;
- БНБД 41-01-11 Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер;
- MNS 6799:2019 Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага;
- MNS 5802:2007 Барилгын цонх Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 4753:2011 Наамал шилэн багц. Техникийн шаардлага;
- MNS 5566:2020 Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм;
- UCS 2001C:2023 Дуу чимээ, дулаан тусгаарлах материалд тавигдах ерөнхий шаардлага;
- UCS 2002A:2023 Дуу чимээний бохирдлыг бууруулах технологи, арга зүйн удирдамж;
- UCS 1001A:2023 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх арга зүйн удирдамж.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Сургуулийн өмнөх боловсрол – гэж бүх нийтийн анхдагч шат, хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд орох хүртэлх хугацаанд хөгжүүлэн төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, чадвар, дадал, үнэт зүйлсийн тогтолцоо;

Хүүхдийн цэцэрлэг – хоёр наснаас сургуульд элсэх хүртэл насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллага;

Эргономик – гэж хүний хөдөлгөөн, орон зайнаас хамааруулан ажиллаж амьдрах, ая тухтай орчин бүрдүүлэх нөхцөлийг судлах агуулгаар архитектурт хэрэглэгддэг нэр томьёо;

Брайл – гэж хараагүй хүн гараараа тэмтэрч уншдаг товгор үсэг;

Паскдах – гэж эд юмны ирмэгийг дарах;

Хөвөө – гэж эд юмны амсар, зах, ирмэг;

Хатжуулсан шил – гэж энгийн шилийг бодоход 4-5 дахин бат бөх бэхжүүлсэн, аюулгүй шил.

4. ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 4.1. Хүүхдийн насны онцлог болон биеийн хөдөлгөөнд тохирсон, тухтай, аюулгүй орчныг бүрдүүлэх эргономик төлөвлөлт хийнэ.
- 4.2. Цэцэрлэгийн барилгын дотор засалд дараах нийтлэг шаардлагыг хангуулна. Үүнд:
 - эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлсэн байх;
 - хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг хангасан байх;
 - ашиглалтын үеийн засвар үйлчилгээ хийхэд хялбар байх;
 - хүүхдийн өндөр, харааны түвшин, хүрэх түвшинд нийцүүлж төлөвлөх.
- 4.3. Тавилга, тоног төхөөрөмжийн өндөр, өргөн нь хүүхдийн насанд тохирсон байна.

Хүснэгт 1. Хүүхдийн эргономик хэмжээ (жишээ)

Нас	1 нас	2 нас	3 нас	4 нас	5 нас	6 нас
Өндөр (см)	75	85	94	101	108.5	115
Харааны түвшин (см)	64	74	83	91	96	103
Хүрэх түвшин (см)	30	36	42	48	52	57

- 4.4 Цэцэрлэгийн барилгын үндсэн өрөө тасалгааны бүрдэл, талбайн хэмжээг БНБД 31-24-22 –т заасан дараах шаардлагын дагуу төлөвлөнө. Үүнд:

Хүснэгт 2. Үндсэн өрөө тасалгааны 1 хүүхдэд ногдох талбайн хэмжээ, м²-аар

Өрөөний нэр	3 нас хүртэлх	3 наснаас сургуульд элсэх нас хүртэлх
Бүлгийн өрөө (тоглох, хооллох)	2.5	2.0
Унтлагын өрөө	1.8	2.0

- 4.4.1. Бүлгийн нэмэлт өрөө тасалгааны ариун цэврийн өрөө 16 м²-аас багагүй, хувцас солих өрөө 18 м²-аас багагүй байна.
- 4.4.2. Тэргэнцэртэй хүүхдийн хөдөлгөөнд зориулсан орон зайг дараах байдлаар төлөвлөнө. Налуу замын уртын дагуу 9м тутамд тэргэнцрийн эргэлтийн диаметрт тохируулж 1.0-1.4м өргөн талбай төлөвлөнө. Гарц, хаалганы өргөн 0.9м - 1.5м-ээс багагүй, өрөө тасалгааны дотор тавилгын хоорондуур явж өнгөрөх замын өргөн 1.2м-ээс багагүй, суултуурт хажуу талаас нь хүрч суух ариун цэврийн өрөөний өргөн нь 1.65м-ээс багагүй байна.
- 4.5. Цэцэрлэгийн дотор засалд хүүхдийн аюулгүй тоглох, сурч хөгжих нөхцөлийг бүрдүүлэн дараах иж бүрдлүүдийг барилгын онцлогтой уялдуулан гүйцэтгэнэ.
 - Хана;
 - Шал;
 - Шат;
 - Цонх;
 - Хаалга;
 - Гэрэлтүүлэг, цахилгааны тоноглол;
 - Халаалт, агааржуулалт болон холбогдох тоноглол.

- 4.6. Цэцэрлэгийн анги танхимын тавилга хэрэгслийг хөдөлгөөнгүй, тогтвортой байрлуулж, хүүхэд бэртэж, гэмтэхээс урьдчилан сэргийлсэн байна.
- 4.7. Барилгын дотор засал болон их засварын ажлыг сургалтын үйл ажиллагааг эхлэхээс 1 сарын өмнө бүрэн дуусгасан байхаар төлөвлөнө.

5. МАТЕРИАЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 5.1. Дотор заслын ажилд усан суурьтай, хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй чанарын гэрчилгээтэй материалыг хэрэглэнэ.
- 5.2. Цахилгааны аюулгүй байдлыг хангасан, галд тэсвэртэй материалыг сонгон ашиглана.
- 5.3. Дараах материалуудыг хэрэглэхийг хориглоно. Үүнд:
 - Хурц үнэртэй;
 - Эрүүл ахуйн шаардлага хангаагүй, чийг шингээдэг;
 - Хэрэглэхийг хязгаарласан химийн бодисын жагсаалтад багтсан найрлагатай.
- 5.4. Төмөр, шил болон хүнд бүтээц, эдлэлийг хэрэглэхдээ аюулгүй байдлыг хангах.
- 5.5. Дотор засалд ашиглах модон материал нь заавал өнгөлгөөтэй байх ба өнгөлгөөний материал нь хүүхдийн эрүүл мэндэд хоргүй байна.

6. ХАНА

- 6.1. Дотор хана нь аюулгүй, цэвэрлэхэд хялбар, эрүүл ахуйд нийцсэн, хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон хийцлэлтэй байна.
- 6.2. Дотор хана нь дараах хэлбэр хийцлэлтэй байхыг хориглоно. Үүнд:
 - Хурц ирмэгтэй;
 - Барзгар гадаргуутай;
 - Цахилгааны утас ил гарсан;
 - Халаалтын төхөөрөмж ил гарсан;
 - Гоёлын зориулалттай хэт төвийсөн эсвэл хонхойсон хийцлэлтэй.
- 6.3. Цэцэрлэгийн барилгын багана болон хана нь дугуй булантай эсвэл булангийн ирмэгийг дарж паскадсан байна.
- 6.4. Багана болон ханын булангийн паск нь шалнаас 30см-200см хүртэлх хэсгийн ирмэгийг дарж паскадсан байна.
- 6.5. Ханыг будахдаа доод тал нь хөвөө хүртэл, дээд тал нь таазнаас доош 10см байхаар будна.
- 6.6. Хана нь зөөлөн ногоон, цайвар цэнхэр, цайвар шаргал, бүдэг ягаан, бэйж гэх мэт зөөлөн уусмал өнгөтэй байна.
- 6.7. Хана нь хурц тод өнгөтэй байхыг хориглоно.
- 6.8. Бүлгийн өрөөний хананд хэт эрээн зураг, ханын цаас ашиглахыг хориглоно.
- 6.9. Хананд чийг шингээдэг материал болон ус даах чадвартай ханын цаас ашиглахыг хориглоно.
- 6.10. Урлаг болон биеийн тамирын хичээлийн танхимын хана, таазны өнгөлгөө нь ШҮ ба Ш1 ангиллын материалаар хийгдсэн байна.
- 6.11. Барилгын модон хана, дотор хана, таазны гадаргууг галд тэсвэртэй заслын


материалаар норм, дүрмийн дагуу бүрсэн нь галын аюулын ШҮ ангиллын нөхцөлийг хангах ёстой.

- 6.12. Ханаар нэвтрэх дуу чимээг бууруулахын тулд дуу чимээ тусгаарлагч гипсэн хавтан, цемент, тоосго гэх мэт материалыг ашиглах ба UCS2002A:2023, UCS2001C:2023 стандарт, удирдамж арга зүйн баримт бичгүүдийг удирдлага болгосон байна.

7. ШАЛ

- 7.1. Шал нь халтирдаггүй, аюулгүй, цэвэрлэхэд хялбар, эрүүл ахуйд нийцсэн, хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон хийцлэлтэй байна.
- 7.2. Шал нь дараах хэлбэр хийцлэлтэй байхыг хориглоно. Үүнд:
- Халтирдаг;
 - Хэт хатуу, цохилт шингээдэггүй;
 - Барзгар гадаргуутай;
 - Цахилгааны ил гарсан утас, тоноглол, разетка;
 - Тэгш бус гадаргуутай.
- 7.3. Ш2-оос илүү ангиллын галын аюултай барилгад гоёл чимэглэлийн өнгөлгөөний материал, шалны өнгөлгөөний материал ашиглахыг хориглоно.
- 7.4. Өрөөний зориулалтаас хамаарч шалны материалыг сонгоно.
- 7.5. Шал нь дулаалгатай хулдаас, үйсэн шал, паркетан шал гэх мэт хүүхдэд аюулгүй, цэвэрлэхэд хялбар байна.
- 7.6. Урлаг зааланд дуу тусгаарлах зорилгоор цэвэрлэхэд хялбар материалтай хивс, хивсэнцэр ашиглаж болно.
- 7.7. Шалаар нэвтрэх дуу чимээг бууруулах зорилгоор шалны өнгөлгөөн доор дуу тусгаарлагч материал хийхдээ UCS2002A:2023, UCS2001C:2023 стандарт, удирдамж арга зүйн баримт бичгүүдийг удирдлага болгосон байна.
- 7.8. Цэцэрлэгийн барилга дотор шалны түвшний өндрийн зөрүү 1.0м-ээс дээш хэмжээтэй бол 1.2м-ээс багагүй өндөртэй хашлага, бариул төлөвлөнө. Оюуны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан барилгад 1.5м-1.8м-ээс багагүй өндөртэй үргэлжилсэн тортой хашлагатай байх.
- 7.9. Цэцэрлэгийн ариун цэврийн өрөөний шал нь нэг түвшинд, халтирдаггүй, ус чийгт тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар материалтай байна.
- 7.10. Ариун цэврийн өрөөний шаланд хэт товгор судалтай, гялгар, зориулалтын бус өнгөлгөөтэй болон цагаан өнгийн плита ашиглахыг хориглоно.
- 7.11. Ариун цэврийн өрөөний шаланд 20см:20см эсвэл 30см:30см хэмжээтэй жижиг плита ашиглана.
- 7.12. Плита хоорондын чигжээсийг зай завсаргүй, плитаны дээд түвшнээс илүү гаргахгүй нэг түвшинд хийж гүйцэтгэнэ.
- 7.13. Ариун цэврийн өрөөний шаланд плита наахаас өмнө чанарын шаардлага хангасан, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй ус тусгаарлагчийг заавал хийх бөгөөд гялгар уут дэвсэхийг хориглоно.
- 7.14. Ариун цэврийн өрөөний шалан дээр хүүхэд халтирч унахаас сэргийлэн гулсдаггүй, ус нэвтрүүлдэггүй, чийгт тэсвэртэй шалавч ашиглана.


Ариун цэврийн өрөөний шалны хэсэглэл



Зураг 1. Ариун цэврийн өрөөний шалны хэсэглэл (жишээ зураг)

8. ШАТ, ХАШЛАГА

- 8.1. Шатны бариул нь модон, резинэн бүрээстэй зэвэрдэггүй ган, хөнгөн цагаан, никель зэрэг материалаар хийгдсэн байхаас гадна хүүхдийн өндрийн хэмжээнд тохирсон байна.
- 8.2. Шатны бариулыг хоёр эгнээгээр байрлуулж, тэдгээрийн өндөр нь насанд хүрэгчдэд 70-90см, сургуулийн өмнөх насны хүүхдэд 50см өндөртэй байхаар төлөвлөнө.
- 8.3. Бариулын хийц, хэмжээ нь дугуй хэлбэртэй бол диаметр нь 3-5см, тэгш өнцөгт хэлбэртэй бол хөндлөн огтлолын зузаан 4см, хана, бариул хоёрын хоорондох зай шахах 4,5см байна.
- 8.4. Шатны хашлага хоорондын зай 10 см-ээс ихгүй байна.
- 8.5. Хамгаалах хашлаганы материал нь гөлгөр гадаргуутай байх ба гагнуурын холбооснуудыг сайтар зүлгэж хурц ирмэг, шовх өнцөг гарахаас сэргийлсэн байна.




Зураг 2. Шатны стандарт (жишээ зураг)


- 8.6. Шат нь халтирдаггүй материалтай эсвэл халтирахаас сэргийлсэн хамгаалалттай байна.
- 8.7. Шатны ирмэгийн хамгаалалт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- өндөр нь 4мм-ээс ихгүй;
 - өргөн нь 5см–5.5см;
 - шалны өнгөнөөс тод ялгаралтай.
- 8.8. Шатны эхлэл болон төгсгөлийн гишгүүрийн ирмэгийг уртын дагуу тод шар өнгөөр тэмдэглэж, аюулгүй байдлыг хангана.
- 8.9. Шатны гишгүүр дээр цэцэг байрлуулах, зураг зурах гэх мэт хүүхдийн анхаарлыг сарниулж, аюулгүй зорчиход саад болох зүйлсийг хориглоно.
- 8.10. Харааны бэрхшээлтэй хүнд зориулсан анхааруулах блокуудыг шаардлагатай газруудад мөн шатны эхлэл, төгсгөлд эхний гишгүүрийн захаас 30см зайтай нийт өргөний хэмжээтэй суурилуулна.

Хүснэгт 3. Анхааруулах хавтангийн хэмжээ (жишээ)

Тэмдэглэгээ	Хэмжээ	Хүлцэх алдаа
a	12	+1.5
a'	a+10	
b	55~60	
c	5	+1.0



- 8.11. Харааны бэрхшээлтэй хүнд мэдээлэл авах зориулалттай брайл үсэг, хэвлэмэл үсгэн тэмдэглэгээг шатны өгсөх, уруудах бариул дээр суурилуулна.



Зураг 3. Брайл тэмдэглэгээг шатны бариул дээр суурилуулах (жишээ зураг)


9. ЦОНХ

- 9.1. Цонх нь 3 давхар шилтэй, эрчим хүчний хэмнэлттэй Low-E бүрхүүлтэй шилтэй байна.
- 9.2. Цонхны үндсэн бүрдэл эд анги болох шилэн багц, нягтруулах жийрэг, түгжээний хэрэгсэл өнгөлгөөний материал, цавуунд ашиглалтын найдвартай ажиллагааны туршилт хийж баталгаажуулсан байна.

- 9.3. Бүлгийн өрөө, ариун цэврийн өрөөний цонхны салхивчийг цонхны дээд талд байрлуулах бөгөөд унжиж онгойдог хөшүүрэгтэй байна.
- 9.4. Цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг хамгаалахын тулд цонхны салхивчинд нарийн тоосонцор, утааны бохирдлыг шүүх, шавжаас хамгаалах нарийн шүүлтүүртэй байна.
- 9.5. Шүүлтүүр нь бат бөх, угсарч суурилуулах, засвар сайжруулалт, цэвэрлэгээ хийхэд хялбар байна.
- 9.6. Цонхны салхивч нь хамгаалалтын тортой байж болно. Хамгаалалтын торны төмөр тус бүр 25кг даац авах чадвартай байх бөгөөд торны төмөр хоорондын зай 10см-ээс ихгүй байна.

10. ХААЛГА

- 10.1. Цэцэрлэгийн анги танхимын хаалга нь дараах нийтлэг шаардлагыг хангуулна.
Үүнд:
 - Модон материалаар хийгдсэн;
 - Хөнгөн;
 - Хүүхдийн хуруу хавчихааргүй;
 - Хаалганы булан ирмэг дугуй хүрээтэй;
 - Далд нугастай;
 - Хаалга хамгийн багадаа 900 нээгддэг;
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг хангасан;
 - Хаалганы хавтсыг байгальд ээлтэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, материалаар хийнэ.
- 10.2. Цэцэрлэгийн анги танхимын хаалга нь гэгээвчтэй байна.
- 10.3. Цонх нь эвдрэлээс сэргийлж хатжуулсан шилтэй байна.
- 10.4. Шиллэгээтэй хаалганы цонхны доод ирмэг нь шалнаас дээш 100–120 см өндөрт байрлана.
- 10.5. Хаалганы харьцаа нь хамгийн багадаа өргөн 90см, өндөр 210 см байна.



Зураг 4. Дотор хаалганы хэмжээс (жишээ зураг)

- 10.6.Цонх, хаалганы тоног, хэрэгсэл, бэхэлгээний эд ангиудад хамгаалалт, гоёлын бүрээс хийсэн байна.
- 10.7.Хаалга нь босгогүй эсвэл хаалганы босго нь шалнаас дээш цухуйхгүй байхаар суурилуулагдсан байна.
- 10.8.Хаалга нь ангиас гадагш онгойлттой, хүүхэд дотроосоо цоожлох боломжгүй байна.
- 10.9.Хаалга хүчтэй хаагдахаас хамгаалсан механизм суурилуулсан байна.


11. ГЭРЭЛТҮҮЛЭГ, ЦАХИЛГААНЫ ТОНОГЛОЛ

- 11.1.Цэцэрлэгийн барилгын өрөө тасалгааны зохиомол гэрэлтүүлгийн эх үүсвэрт тавигдах шаардлагыг БНБД 23-02-08-ын дагуу төлөвлөнө.
- 11.2.Өрөө тасалгаанд байвал зохих зохиомол гэрэлтүүлгийн хэмжээг хүснэгт 4-т заасан үзүүлэлтийг баримтална.

Хүснэгт 4. Өрөө тасалгаанд байвал зохих гэрэлтүүлгийн хэмжээ

№	Өрөөний нэр	Ерөнхий гэрэлтүүлэгтэй үед /люкс/	Гэрэлтэлтийн хэлбэлзлийн итгэлцүүр %, ихгүй	Таагүй байдлын үзүүлэлт, ихгүй
1	Хүлээн авах	200	15	25
2	Хувцас солих	200	15	60
3	Бүлгийн, тоглоомын, хоолны, хөгжмийн өрөө	400	10	15
4	Гимнастикийн хичээлийн өрөө	400	10	15
5	Унтлагын өрөө	100	15	25
6	Эмчийн өрөө	200	15	25
7	Тусгаарлах өрөө	200	15	25

- 11.3. Гэрэлтүүлэгт эрчим хүчний хэмнэлттэй, удаан эдэлгээтэй лед гэрэл ашиглана.
- 11.4. Бүлгийн өрөөнд гэрэлтүүлэг нь 400 люкс байхаар тооцоолж гэрэлтүүлгийг суурилуулна.
- 11.5. Гэрэлтүүлэг нь удирдлагын системтэй, гэрэлтүүлгийн хэмжээг тохируулах боломжтой байна.
- 11.6. Гэрлийн бүрхүүл нь багадаа шалнаас дээш 2.5м өндөрт байна.
- 11.7. Гэрлийн бүрхүүлийн хийцлэл шилэн бус, хөнгөн, бат бөх, угсарч суурилуулах, засвар сайжруулалт хийхэд хялбар материалыг сонгон хэрэглэнэ.
- 11.8. Гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж нь гадаргуугийн халалт бага, хүүхдийн аюулгүй байдлыг хангахуйц цахилгааны хамгаалалттай байна.
- 11.9. Анги танхимд нарны шууд тусгал, гялбаанаас хамгаалж буулгадаг босоо туузан хөшигтэй байна.
- 11.10.Цахилгааны холболт гэрлийн унтраалга, разетка хийхдээ далд монтажтай, хүүхэд, багшийн үйл ажиллагаанд аюулгүй байдлыг хангасан байна.
- 11.11.Цахилгааны залгуурыг (разетка) шалнаас дээш 1.8м өндөрт байрлуулах ба залгуурыг салгасан үед төхөөрөмжийг хаах хамгаалалттай байна.



Зураг 5. Хамгаалалттай цахилгааны залгуур (жишээ зураг)

12. ХАЛААЛТ, АГААРЖУУЛАЛТ

- 12.1. Цэцэрлэгийн барилгын үндсэн өрөөний агаарын хэм ба агаар сэлгэлтийн тоо хэмжээнд тавигдах шаардлагыг БНБД 41-01-11 болон БНБД 31-24-22 дагуу төлөвлөнө.
- 12.2. Цэцэрлэгийн барилгын халаалтын систем нь өдрийн турш өрөө тасалгааны агаарын дулааны хэлбэлзлийг хамгийн бага байлгах, тасалгааны агаарыг бохирдуулахгүй байх шаардлагуудыг хангасан байна.
- 12.3. Барилгад инженерийн шугам сүлжээний хангамж, халаалтын төхөөрөмж суурилуулсан хэсэгт хүүхэд нэвтрэх боломжгүй, хамгаалалтын хаалт, тор тоноглох бөгөөд дамжуулах хоолой нь дулаан тусгаарлагчтай байна.



Зураг 6. Бүлгийн өрөө (жишээ зураг)

- 12.4. Бүлгийн өрөөний хананд шалнаас 80см-100см-ийн өндөрт дулаан хэмжигч байрлуулж, температурыг хянадаг байна.
- 12.5. Барилгын өрөө тасалгааны доторх агаарын дундаж температур 21°C-24°C харьцангуй чийгшил 45% (+-7%) байна.
- 12.6. Доод давхарт байрлах үндсэн өрөө, унтлагын ба хувцас солих өрөө, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан эмчилгээний өрөөний шалны гадаргуугийн температур 26°C-аас хэтрэхгүй байх.
- 12.7. Анги танхимын агаар сэлгэлтийн хэвийн нөхцөлийг хангах зорилгоор энгийн болон механик агаар сэлгэлтийн төхөөрөмжтэй байна.
- 12.8. Барилгын өрөө тасалгааны доторх агаарын дундаж температур 21°C-24°C харьцангуй чийгшил 45% (+-7%) байна.
- 12.9. Доод давхарт байрлах үндсэн өрөө, унтлагын ба хувцас солих өрөө, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан эмчилгээний өрөөний шалны гадаргуугийн температур 26°C-аас хэтрэхгүй байх.

13. АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨ

- 13.1. Хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүн 1 давхарт 1 бүхээг, хүүхдэд давхар бүрд ариун цэврийн өрөө эсвэл бүлгийн ариун цэврийн өрөөний дотор 1 бүхээгийг БНБД 31-24-22-ын дагуу төлөвлөнө.
- 13.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ариун цэврийн өрөөг UCS1001A:2023 стандартын дагуу төлөвлөнө.
- 13.3. Ариун цэврийн өрөөнд багадаа 10 хүүхдэд нэг суултуур, угаагуур ногдохоор тооцож тоноглоно.
- 13.4. Ариун цэврийн өрөөний тоноглол хэрэгслүүд нь хүүхэд бие даан хэрэглэхэд тохиромжтой, тэдний хөдөлгөөнд саад болохгүй, суултуур – угаалтуур - алчуур, гар хатаагч гэсэн зөв урсгалтай байна.
- 13.5. Ариун цэврийн өрөөний шал, хана, угаалтуур, суултуур нь цэвэрлэхэд хялбар байна.



Зураг 7. Ариун цэврийн өрөө (жишээ зураг)

- 13.6. Ариун цэврийн өрөөнд хүүхдэд зохиулсан суултуур, хөтөвч, гар угаах тосгуурыг байрлуулна.
- 13.7. Ариун цэврийн өрөөний хананд холбогдолгүй зураг наах, тусгаарлагчид хөшиг тогтоох, элдэв чимэглэл хийхгүй байх.
- 13.8. Хөтөвч ашигладаг хүүхэд тус бүр тусдаа хөтөвчтэй байна.
- 13.9. Ариун цэврийн өрөөний суултуурууд хоорондоо тусгаарлагчтай, тусгаарлагчийн хажууд хүүхэд унахаас сэргийлсэн бариултай ариун цэврийн цаасны өлгүүр байрлуулсан байна байна.
- 13.10. Ариун цэврийн өрөөний цаасны өлгүүр нь металл биш, хурц ирмэг өнцөггүй байна.
- 13.11. Ариун цэврийн өрөөний суултуурын усны татуурга нь хүүхэд ашиглахад хялбар доош дардаг байна.
- 13.12. Бүлгийн ариун цэврийн өрөөний хүүхдийн суултуур хоорондын тусгаарлагч 80см х 75см багагүй хэмжээтэй байна.
- 13.13. Хүүхдийн суултуур хоорондын тусгаарлагч нь хурц өнцөг булангүй байхаас гадна шаардлагатай тохиолдолд хамгаалалтын зөөлөвч материал хэрэглэж аюулгүй байдлыг хангана.
- 13.14. Суултуур хоорондын тусгаарлагчийг шил, металл хүрээ, эрүүл ахуйн шаардлага хангаагүй PVC, ДСП хавтангаар хийхийг хориглоно.
- 13.15. Тусгаарлагч самбарын өндөр 120см багагүй байна.
- 13.16. Ариун цэврийн өрөөний суултуурын хэмжээ хүснэгт 5-д заасны дагуу байна.

Хүснэгт 5. Суултуурт тавигдах шаардлага


№	Хэмжээ	2-3 нас	4-5 нас	Тайлбар
1	Суултуурын өндөр (ихгүй)	20см	27-28см	Ердийн суултуурыг шалыг доош ухаж суулгаж болно.
2	Суултуурын урт (ихгүй)	55см	55см	Хананаас суултуурын урд талын хэсэг хүртэлх зай.

- 13.17. Ариун цэврийн өрөөний угаагуур нь хүснэгт 6-д заасны дагуу байна.

Хүснэгт 6. Угаагуурт тавигдах шаардлага

№	Хэмжээ	2-3 нас	4-5 нас	Тайлбар
1	Угаагуурын өндөр (ихгүй)	50см	60см	Шалнаас дээш угаагуурын тавцан хүртэлх зай
2	Угаагуур хоорондын зай (багагүй)	50см	50см	Нэг угаагуурын цоргоноос нөгөө угаагуурын цорго хүртэлх зай
3	Угаагуурын өргөн (багагүй)	40см	50см	Угаагуурын өргөн
4	Толины өндөр (ихгүй)	40см	40см	Угаагуур дээр байрлуулсан толины өргөн

- 13.18. Ариун цэврийн өрөөний суултуур нь охид, хөвгүүдээр нь ялгасан таних тэмдэгтэй байна.

ЭМЭГТЭЙ**ЭРЭГТЭЙ**

Зураг 8. Ариун цэврийн өрөөний таних тэмдэг (жишээ зураг)

- 13.19.24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэгийн бүлгийн ариун цэврийн өрөөнд усанд орох шүршүүр байрлуулна.
- 13.20.Шүршүүрийн хананд хүүхэд унахаас хамгаалсан бариултай байх бөгөөд халтирахаас сэргийлсэн дэвсгэртэй байна.
- 13.21.Шүршүүрийн хананы урт 100см, өргөн 100см, шалнаас шүршүүрийн тавцан хүртэлх зай 40см, шүршүүрийн онгоцны гүн 15см байна.
- 13.22.Тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүний угаалтуур, угаалгын сав ба хөтөвчний бэхэлгээг хүүхдийн биеийн өндрөөс хамаарч өөрчлөх боломжтой төлөвлөнө.

14. АЮУЛГҮЙ БАЙДАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 14.1. Цэцэрлэгийн дотор орчинд багш, албан хаагчид, хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангаж, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэн камер байрлуулна.
- 14.2. Цэцэрлэгийн талбайн хэмжээ, ашиглах хэрэгцээ, шаардлага зэргээс шалтгаалан камерын байрлал, хүчин чадал зэргийг сонгож хэрэглэнэ.
- 14.3. Цэцэрлэгийн бүсэд өдрийн цагт анги танхимд суурь дуу чимээний хүлцэх хэмжээ 35 дБА-аас хэтрэхгүй байна.
- 14.4. Цэцэрлэгийн барилга, байгууламжийг барих, засварлах ажилд дуу чимээ, дулаан тусгаарлах материалыг сонгон хэрэглэхдээ UCS2002A:2023, UCS2001C:2023 хотын стандартын шаардлагыг хангасан байна.
- 14.5. Дуу чимээ, чичиргээний эх үүсвэр болох тоног төхөөрөмж бүхий техникийн өрөөг бүлгийн өрөө, хүмүүс байнга (ажлын цагаар) ажилладаг өрөөний зэргэлдээ байрлуулан төлөвлөхгүй байх.
- 14.6. Цэцэрлэгийн барилга нь галын болон аюулгүй байдлын дохиоллын системтэй байна.

- 14.7. Цэцэрлэг нь гал унтраагч системтэй байх ба MNS 5566:2020 “Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм” стандартыг хангана.
- 14.8. Цэцэрлэгт болзошгүй, гэнэтийн аюулын үед авах арга хэмжээний бүдүүвч зургийг гаргаж, нийтэд харагдахаар газар байрлуулна.
- 14.9. Онцгой байдлын гарц болон нүүлгэн шилжүүлэх зам, тэмдэг, тэмдэглэгээ нь тод, харагдах орчныг бүрэн хангаж, саадгүй байхаар төлөвлөнө.
- 14.10. Барилгын халаалтын хэрэгслүүд нь галын аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.
- 14.11. Барилгын дотор заслыг агааржуулалт, гэрэлтүүлэг, температур, чийгшлийн зохистой үед хийж гүйцэтгэнэ.
- 14.12. Цэцэрлэгийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь хүүхдийн бие махбод эрүүл мэнд, хөдөлгөөний хөгжил, аюулгүй байдалд нийцсэн байна.

15. ШАЛГАХ ХУУДАС

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын дотор засал нь шаардлага хангаж байгаа эсэхийг дараах шалгуур үзүүлэлт (хүснэгт 7)-ийн дагуу хянан шалгана.

Хүснэгт 7. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Цэцэрлэгийн ерөнхий өнгө нь зөөлөн, цайвар эсэх	☐	☐
2	Барилгын дотор засалд хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгальд ээлтэй, гэрчилгээгээр баталгаажсан материал ашигласан эсэх	☐	☐
3	Барилгын багана болон хана нь дугуй булантай эсвэл булангийн ирмэгийг дарж паскадсан эсэх	☐	☐
4	Шал нь хүүхдэд аюулгүй, халтирдаггүй цэвэрлэхэд хялбар эсэх	☐	☐
5	Ариун цэврийн өрөөний шал нь нэг түвшинд эсэх	☐	☐
6	Шатны хамгаалалт хоорондын зай нь 10 см-ээс ихгүй эсэх	☐	☐
7	Шат нь халтирдаггүй материалтай эсвэл халтирахаас сэргийлсэн хамгаалалттай эсэх	☐	☐
8	Шат нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг хангасан эсэх	☐	☐
9	Хаалга нь модон материалаар хийгдсэн хөнгөн эсэх	☐	☐
10	Хаалганы цонх нь эвдрэлээс сэргийлж хатжуулсан шилтэй эсэх	☐	☐
11	Цахилгааны залгуурыг (разетка) шалнаас дээш 1.8м өндөрт байрлуулсан эсэх	☐	☐
12	Цахилгааны холболт гэрлийн унтраалга, разетка нь далд монтажтай, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан эсэх	☐	☐
13	Халаалтын төхөөрөмжтэй хэсгийг хамгаалалтын хаалт, тороор тоногдсон эсэх	☐	☐
14	Анги танхимын агаар сэлгэлтийн хэвийн нөхцөлийг хангах зорилгоор энгийн болон механик агаар сэлгэлтийн төхөөрөмжтэй эсэх	☐	☐
15	Ариун цэврийн өрөөнд хүүхдэд зохиулсан суултуур, хөтөвч, гар угаах тосгуурыг байрлуулсан эсэх	☐	☐
16	Барилга нь галын болон аюулгүй байдлын дохиоллын системтэй эсэх	☐	☐
17	Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэлтэй эсэх	☐	☐
18	Цэцэрлэгт болзошгүй, гэнэтийн аюулын үед авах арга хэмжээний бүдүүвч зургийг гаргаж, нийтэд харагдахаар газар байрлуулсан эсэх	☐	☐

Тайлбар: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын дотор засал нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- БНБД 31-03-03 – Олон нийт иргэний барилга;
- БНБД 31-24-22 – Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт;
- БНБД 23-02-08 – Байгалийн гэрэлтүүлэг ба зохиомол гэрэлтүүлэг;
- БНБД 41-01-11 Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер;
- БНБД 41-01-02 – Агаар сэлгэлт ба кондиционерийн системийн ерөнхий барилгын норм ба дүрэм;
- MNS 6055:2009 – Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, үндсэн шаардлага;
- MNS 6799 : 2019 Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага;
- MNS 6558:2015 – Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны ерөнхий шаардлага;
- MNS 6799:2019 Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага;
- MNS 5802:2007 Барилгын цонх Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 4753:2011 Наамал шилэн багц. Техникийн шаардлага;
- MNS 5566:2020 “Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм;
- UCS 1101B:2022 – Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага;
- UCS 1504C:2023 Хаалга, цонхонд тавигдах ерөнхий шаардлага;
- UCS 2001C:2023 Дуу чимээ, дулаан тусгаарлах материалд тавигдах ерөнхий шаардлага;
- UCS 2001A:2023 Дуу чимээний бохирдлын менежмент;
- UCS 2002A:2023 Дуу чимээний бохирдлыг бууруулах технологи, арга зүйн удирдамж;
- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандартыг хэрэгжүүлэх зөвлөмж, 2018;
- Neufert, Ernst. Architects' Data. Fourth Edition. Wiley-Blackwell, United Kingdom, 2012;
- Early childhood facilities design standards and guidelines, government of australia.
- <https://arteviva.com/new-trend-natural-colored-interior-for-kindergartens-and-schools/>

This image shows a single page of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

[illegible]



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын зам 1201,
Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор Б байр



72707700



www.uds.ub.gov.mn



Хот байгуулалт, хотын стандартын газар